

**Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал,
төсвийн хуваарилагдаагүй зардлын 2005 гүйцэтгэл, үр дүн**



**Хуулийн зохицуулалт
шаардлагатай байна**

Ү А Г

Үндэсний аудитын газар

**УИХ-ын Төсвийн Байнгын хорооны хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлан**

Улаанбаатар

2006 оны 5 дугаар сар

Агуулга

| | | |
|--|---|----|
| | Товчилсон үгсийн жагсаалт | 2 |
| Тайланг бэлтгэсэн: | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй | 3 |
| ҮАГ-ын нэгдүгээр газар | Бүлэг 1 | |
| <i>Тэргүүлэх аудитор Д.Ганбилэг</i> | Түр журам бүрэн хэрэгжихгүй байна | |
| <i>Аудитын менежер Ж.Батсайхан</i> | <ul style="list-style-type: none">Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл | 4 |
| <i>Ахлах аудитор Л.Одгэрэл</i> | <ul style="list-style-type: none">Төсвийн хуваарилагдаагүй зардлын дийлэнх хувийг зориулалт бусаар зарцуулахаар шийдвэрлэж хэрэгжүүлжээ | 6 |
| 2006 оны 6 дугаар сар | Зөвлөмж 1 | 7 |
| Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү: | Бүлэг 2 | |
| www.mnao.pmis.gov.mn | Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэлийн тайлагнал хангалтгүй байна | |
| <i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i> | <ul style="list-style-type: none">Төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэсэн зарим байгууллага зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах үүргээ хангалтгүй биелүүлжээ | 8 |
| ХАЯГ: | <ul style="list-style-type: none">Төсөвт зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл буюу хэмнэгдсэн хөрөнгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлэхэд ахиц гарчээ | 9 |
| <i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i> | Өмнөх аудитаар өгсөн зарим зөвлөмж хэрэгжээгүй байна | 10 |
| | Зөвлөмж 2 | 11 |
| | Холбогдох байгууллагын санал | 12 |

Товчилсон үгс

| | |
|---------|--|
| УИХ | Улсын Их Хурал |
| СЭЗС | Санхүү, эдийн засгийн сайд |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ТЗҮААЭГ | Төр засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| ЮНЕСКО | НҮБ-ын хамтын ажиллагааны байгууллага |

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны хүсэлт, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2005 оны гүйцэтгэл, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийв.

Энэхүү аудитын зорилт нь Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2005 оны гүйцэтгэл, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган, зөрчил дутагдал илэрвэл тэдгээрийг цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж өгөхөд чиглэгдэв.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг хэрхэн төлөвлөж, хуваарилсан, талаар судалгаа, тодруулга авах,
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, түүнийг хэрхэн тайлагнасан байдлыг холбогдох байгууллагад түүвэрлэн шалгах,
- Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардалд зарцуулсан хөрөнгийг баталсан төсөвтэй нь харьцуулан дүн шинжилгээ хийх,
- Шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, хүмүүсээс тайлбар, нотолгоо авах, ярилцлага хийх,

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт, материалд хавсаргав.

Бүлэг 1

Түр журам бүрэн хэрэгжихгүй байна



Танилцуулга

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Монгол Улсын 2005 оны төсвийн тухай хуулиар Засгийн газрын нөөц санд 2,0 тэрбум, төсвийн хуваарилагдаагүй зардалд 1,0 тэрбум төгрөг батлагдаж, болзошгүй эрсдэлийг нөхөх зардалд хөрөнгө батлагдаагүй байна.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэрээс 26 төсөл, арга хэмжээнд 2038,0 сая, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс 38 төсөл, арга хэмжээнд 1051,1 сая, бүгд 3089,1 сая төгрөг зарцуулахаар холбогдох шийдвэр гарчээ.

СЭЗС-ын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам”-ын (цаашид “түр журам” гэх) 2 дугаар бүлэгт Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүнд

шаардагдах зардлыг төлөвлөх, хуваарилахад харгалзах шалгуур үзүүлэлт, баримтлах зарчмыг тодорхойлжээ. Тухайлбал:

- Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын тухайн жилийн төсөвт тусгах хэмжээг цаг уурын болон байгалийн гамшигтай холбогдсон урьдчилсан төсөөлөл гаргах эрх бүхий байгууллагын мэдээлэл, судалгаа,
- Сүүлийн жилүүдийн бараа, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн хэлбэлзэл, өсөлт, дээрх зардлын өмнөх жилүүдийн гүйцэтгэл, төсвийн хүрэлцээ, багтаамж,
- Дээрх сан болон зардлын нийт хэмжээ нь тухайн жилийн ДНБ-ний 1,5-2,0 хувиас хэтрэхгүй байх зарчим баримтлах.

Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2003-2005 оны гүйцэтгэлээс харахад зардлыг 2003, 2004 онд ижил хэмжээгээр төлөвлөж, 2005 онд өмнөхөөс 2 дахин багаар төлөвлөж батлуулжээ.

Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэлийн судалгаа

/ сая.төг/

| д/д | Үзүүлэлт | 2003 | | | 2004 | | | 2005 | | |
|-----|---|--------|-----------|-------|--------|-----------|-------|--------|-----------|-------|
| | | Төл | Гүйц | Зөрүү | Төл | Гүйц | Зөрүү | Төл | Гүйц | Зөрүү |
| 1 | Засгийн газрын нөөц сан | 4000,0 | 3821,8 | 178,2 | 4000,0 | 3990,4 | 9,6 | 2000,0 | 1851,6 | 148,4 |
| 2 | Болзошгүй эрсдэлийг нөхөх зардал | - | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Төсвийн хуваарилагдаагүй зардал | 2030,9 | 1874,2 | 156,7 | 2030,9 | 1527,2 | 503,7 | 1000,0 | 997,1 | 2,9 |
| | Нийт зардлын дүн | 6030,9 | 5696,0 | 334,9 | 6030,9 | 5517,6 | 513,3 | 3000,0 | 2848,7 | 151,3 |
| 4 | Дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр / | | 1461169,2 | | | 1910880,9 | | | 2266505,5 | |
| 5 | Нийт зардлын Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 0,4 | | | 0,3 | | | 0,1 | | |

Судалгаанаас үзэхэд Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын батлагдсан төсөв буурч, ДНБ өссөнтэй холбоотойгоор Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын ДНБ-нд эзлэх хувийн жин жил тутам буурчээ.

Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх үйл ажиллагаанд шаардагдах мэдээлэл, судалгааг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, хянах талаар Сангийн яам өөрийн гаргасан түр журмыг чанд мөрдөөгүй байна.

Засгийн газрын нөөц сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гол зардал болох улс орны болон бүс нутгийн чанартай байгалийн гамшиг, нийтийг хамарсан аюул бүхий гоц халдварт өвчний голомтыг арилгах, тархалтыг хязгаарлах, таслан зогсоох, үйлдвэрлэлийн ноцтой аюултай холбогдож гарсан шууд зардал, хохирсон хүмүүст олгох тэтгэмж, тусламж, ослын үр дагаврыг арилгах чиглэлээр үзүүлэх арга хэмжээнд 1234,4 сая төгрөг буюу 60,6 хувийг, улсын төсөвт нэг бүрчлэн тооцож тусгах боломжгүй, цаг үеийн нөхцөл байдлын улмаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуудлуудыг шийдвэрлэхэд 803,6 сая төгрөг буюу 39,4 хувийг зарцуулахаар шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийг тус бүрээр нь хавсралт №1-д үзүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуудлуудыг шийдвэрлэхэд зарцуулсан хөрөнгийн 26,1 хувийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон тангараг өргөх ёслолын зардал, 18,7 хувийг “ЭКСПО-2005” дэлхийн үзэсгэлэнд оролцох зардал, 15,4 хувийг гадаад дотоодын төлөөлөгчдийг хүлээн авах зардал, 17,6 хувийг Олон улсын байгууллагын гишүүний татвар болон Засгийн газрын нэрийн өмнөөс хуульч хөлслөх зардал, 6,0 хувийг гадаад орнуудад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зардал, 14,8 хувийг бусад зардал, 1,4 хувийг зарим иргэдийн эмчилгээний зардал тус тус эзэлж байна.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн эх үүсвэрээр 2005 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг холбогдох шийдвэр тус бүрээр хавсралт №1-д үзүүлэв.

Төсвийн хуваарилагдаагүй зардлын дийлэнх хувийг зориулалт бусаар зарцуулахаар шийдвэрлэж хэрэгжүүлжээ

Төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг хэрхэн хуваарилж, шийдвэрлэсэн байдлыг түр журмын 3 дугаар зүйлийн Б-д заасан зардлын зориулалттай харьцуулсан судалгааг хавсралт № 2-т үзүүлэв.

Судалгаанаас үзэхэд төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн нийт хөрөнгийн 28,6 хувь буюу 300,4 сая төгрөгийг түр журамд заасан зориулалтын дагуу хуваарилж, 71,4 хувь буюу 750,7 сая төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулахаар шийдвэрлэжээ.

Зориулалт бусаар зарцуулсан нийт хөрөнгийн 42,2 хувь буюу 316,6 сая төгрөгийг техник, тоног төхөөрөмж авахад, 21,2 хувь буюу 159,1 сая төгрөгийг тэмдэглэлт ойн арга хэмжээнд, 18,3 хувь буюу 137,1 сая төгрөгийг гадаад орнуудад болсон хурал, зөвлөлгөөний зардалд, 2,2 хувь буюу 17,0 сая төгрөгийг зарим иргэдийн эмчилгээний зардалд, 1,9 хувь буюу 14,6 сая төгрөгийг бусад арга хэмжээний зардалд тус тус зарцуулах шийдвэр гаргаж хэрэгжүүлжээ.

Энэ нь Сангийн яамнаас гаргасан түр журам дээрх асуудлыг зохицуулж чадахгүй байгааг харуулж байна .

Үндэсний аудитын газар түр журмыг хуулиар зохицуулах шаардлагатай гэсэн зөвлөмжийг өмнө нь 2 удаа өгсөн байна.

Зөвлөмж :

Сангийн сайд Н.Баяртсайханд:

Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, тайлагнах түр журмыг хуульчлах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх

Бүлэг 2

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэлийн тайлагнал хангалтгүй байна



Танилцуулга

Төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэсэн зарим байгууллага зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнах үүргээ хангалтгүй биелүүлжээ

Түр журамд Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрхэн санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, хянах талаар дараахь зохицуулалт тусгагджээ. Үүнд:

- Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардалд төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалтад урьдчилсан хяналт, санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх, гүйцэтгэлийг тайлагнах, хянах үүргийг Төрийн сангийн газарт хариуцуулсан
- Холбогдох шийдвэрийг үндэслэн тухайн төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэх байгууллага нь холбогдох төсөв, түүний гүйцэтгэлийг үнэн зөв гаргаж Төрийн сангийн газарт тайлагнах үүрэг хүлээсэн

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлийг хэрхэн тайлагнасан талаархи судалгааг хавсралт №1,2-т үзүүлэв.

Судалгаанаас харахад төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэсэн байгууллагууд Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлаас зарцуулсан 2848,7 сая төгрөгийн 13,4 хувь буюу 381,1 сая төгрөгийн гүйцэтгэлийг хагас дутуу тайлагнасан буюу зардлын гүйцэтгэлийн тайланг тогтоосон хугацаанд Төрийн сангийн газарт бүрэн өгөөгүй байна.

Аудитаар Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлийг холбогдох байгууллагууд дутуу тайлагнасан, тайлант онд зарцуулагдаагүй үлдэгдлийг зарцуулсан мэтээр буруу тайлагнасан, хөрөнгийн зарцуулалтын үндсэн баримт материалыг дутуу бүрдүүлсэн, шагнал, урамшуулал, ажлын хөлснөөс хүн амын орлогын албан татвар аваагүй зэрэг 43,0 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, холбогдох арга хэмжээ авлаа.

Эх орончдын болон ардчилал, хүний эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд зарцуулсан хөрөнгийн тайлагнал хангалтгүй, ялангуяа үндсэн баримтын бүрдэл дутуу, ойн арга хэмжээнд зарцуулсан шагнал, урамшуулал, ажлын хөлсний дүнд хүн амын орлогын албан татвар ногдуулж аваагүй байна.

Эх орончдын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 23,8 сая, Ардчилал, хүний эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд 10,3 сая, бүгд 34,1 сая төгрөгийг зарцуулжээ.

Дээрх зөрчил дутагдал жилээс жилд давтагдаж байгаа нь Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэгч байгууллага санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль тогтоомжийг биелүүлээгүй, Сангийн яамны Төрийн сангийн газраас дээрх зардлын гүйцэтгэлийг тайлагнах горим, нэгдсэн аргачлал, заавар гаргаж мөрдүүлээгүйтэй холбоотой байна.

Төсөвт зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл буюу хэмнэгдсэн хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхэд ахиц гарчээ

Сангийн яамны Төрийн сангийн газар түр журмын 5.25-д "Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэх байгууллага нь уг зардлаас хэмнэсэн хөрөнгө буюу зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрсөн төсвийн холбогдох дансанд эргүүлэн шилжүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн дараахь байгууллагуудын хэмнэгдсэн хөрөнгийг төсвийн холбогдох дансанд төвлөрүүлжээ. Үүнд:

Засгийн газрын нөөц сангаас:

- УИХ-ын Тамгын газарт Засгийн газрын 2005 оны 60 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардалд олгосон хөрөнгөөс 118.1 сая,
- УИХ-ын Тамгын газарт Засгийн газрын 2005 оны 230 дугаар тогтоолоор Вьетнам-Зөвлөлтийн сансрын хамтарсан нислэгийн 25 жилийн ойд оролцох төлөөлөгчдийн зардалд олгосон хөрөнгөөс 0.2 сая,

Төсвийн хуваарилагдаагүй зардлаас:

- Сангийн сайдын 2005 оны 50, 75, 90 дүгээр тушаалаар Гадаад хэргийн яаманд олгосон гадаадад болсон хурал, зөвлөгөөнд оролцох Монголын талын төлөөлөгчдийн зардалд олгосон хөрөнгөөс 5,2 сая,
- Сангийн сайдын 2005 оны 70 дугаар тушаалаар Сангийн яаманд НББ-ийн улсын үзлэг явуулах зардалд олгосон хөрөнгөөс 1.5 сая,
- Сангийн сайдын 2005 оны 140 дугаар тушаалаар Хүний эрхийн үндэсний төвд Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганыг Улаанбаатарт зохион байгуулах зардалд олгосон хөрөнгөөс 1.7 сая,
- Сангийн сайдын 2005 оны 159 дүгээр тушаалаар ТЗҮААЭГ-т Ерөнхий сайдын Европын орнуудад хийсэн айлчлалын зардалд олгосон хөрөнгөөс 4,5 сая,
- УИХ-ын 2005 оны 45 дугаар тогтоолоор Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд УИХ-ын 65-р тойргийн нөхөн сонгуулийн зардалд олгосон хөрөнгөөс 0,2 сая, бүгд 131.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Энэ нь өмнөх онтой харьцуулахад ахицтай байна.

Засгийн газрын нөөц сан, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хариуцсан зарим байгууллага уг зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг төсөвт төвлөрүүлээгүй байсныг аудитын явцад илрүүлж, төлбөрийн акт бичив. Тухайлбал:

- Ерөнхий сайдын 2005 оны 95 дугаар захирамж, Сангийн сайдын 2005 оны 197 дугаар тушаалаар Өндөр гэгээн Занабазарын 370 жилийн ойд зориулж төсвийн хуваарилагдаагүй зардлаас олгосон хөрөнгөөс 3,0 сая,
- Засгийн газрын 2005 оны 18 дугаар тогтоолоор Хархорин хотыг орчин үеийн жишиг хот болгон хөгжүүлэх төсөл боловсруулахад олгосон хөрөнгөөс 6,8 сая,
- Засгийн газрын 2005 оны 70 дугаар тогтоолоор ЮНЕСКО-оос зохион байгуулж байгаа "Төв азийн орнуудын соёлын олон төрөл байдал" сэдэвт олон улсын их наадамд оролцох монголын төлөөлөгчдийн зардалд олгосон хөрөнгөөс 0,1 сая,
- Засгийн газрын 2005 оны 26, 31 дугаар тогтоолоор өвөлжилтийн байдал хүндэрсэн баруун аймгууд, тухайлбал, Баян -Өлгий аймагт өвс, тэжээл хүргэх зардалд зориулан олгосон хөрөнгөөс хувьдаа ашигласан 3,7 сая бүгд 13,6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр акт бичив.

Өмнөх аудитаар өгсөн зарим зөвлөмж хэрэгжээгүй байна.

Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2004 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнг шалгахад:

- Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнаагүй байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч, шаардлагатай тохиолдолд банкинд дахь харилцах дансны гүйлгээг тодорхой хугацаагаар хаах хүртэл арга хэмжээ авсны үр дүнд 1881,1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний зардлын гүйцэтгэлийн тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авчээ.
- Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ урьдчилгаа олгох замаар гүйцэтгэлээр санхүүжүүлэх, зарцуулагдаагүй, хэмнэгдсэн хөрөнгийг төсөвт төвлөрүүлэх зарчим баримтлан ажиллаж зохих үр дүнд хүрчээ.
- Нэгдсэн төсвийн тухай хуулийн 13.3-д заасны дагуу "Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг зарцуулах журам"-ын тухай хуулийн төслийг боловсруулан, Төсвийн Ерөнхийлөн захирагчдын саналыг 2 удаа авч Засгийн газрын хуралдаанаар 3 удаа хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байгаа боловч эцэслэн шийдвэрлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ: 2

Сангийн сайд Н.Баяртсайханд:

- Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэлийн тайлагналд онцгой анхаарч, тайланг хагас дутуу ирүүлсэн, буруу тайлагнасан холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцож, зардлын гүйцэтгэлийг тайлагнах нэгдсэн загвар маягыг боловсруулж, мөрдүүлэх
- Эх орончдын болон ардчилал, хүний эрхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд намуудад хөрөнгө хуваарилж, олгохгүй байх
- Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх арга хэмжээ авах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

210848 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэсний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 32-02-47, <http://www.parliament.mn>

2006.06.21 № 549/2698
талбай _____ -ын № _____ -т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Засгийн газрын нөөц сан, боловшгүй эрсдлийг
нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2005
оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцаад саналыг хэвсрэлтөөр хүргүүлж
байна.



Н.БАЯРТСАЙХАН

№ 0729

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2006 оны 5-р дугаар тушаалын хавсралт

Засгийн газрын нөөц сан, болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилгаагүй зардлын
2005 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн
төлбөр, зөрчлийн жагсаалт

| № | Байгууллагын нэр | Төлбөр хариуцагчийн | | Төлбөр, зөрчлийн товч утга | ᠳᠠᠵᠢᠨ | Төлбөрийн дүн | Зөрчлийн дүн | Үүнээс | |
|-----------------|------------------------------------|--------------------------------------|---|--|-------|----------------|----------------|----------------|--------------|
| | | Нэр | Албан тушаал | | | | | Төсөвт | байгууллагад |
| 1 | Өвөрхангай ЗДТГазар | Ч.Чинбат Д.Нэмэхбаяр | Засаг даргын орлогч Санхүүгийн хэлтсийн дарга | Өндөргэгээн Занабазарын 370 жилийн ойд зориулсан хөрөнгөөс хэмнэгдсэн | 07 | 3000,0 | | 3000,0 | |
| 2 | Соёл урлагийн сан | Н.Бямбажав П.Солонго | Сангийн захирал Ня-бо | Олон улсын их наадамд оролцох зардлаас хэмнэгдсэн | 03 | 147,7 | | 147,7 | |
| 3 | Баян-Өлгий Улсын нөөцийн салбар | Ж.Амонжол М.Ерболат К.Каримхан | Салбарын дарга Ня-бо Салбарын дарга байсан | Засгийн газрын нөөц сангаас ОБЕГ-аар дамжуулан өвс, тэжээл тээвэрлэх зардалд олгосон хөрөнгөөс хувьдаа ашигласан | 26 | 3566,7 | | 3566,7 | |
| 4 | Сангийн яамны Төрийн сангийн газар | Х.Пүрэвсүрэн Х.Ундраа | Дарга Ахлах мэргэжилтэн | "Хархорин төсөл" хөтөлбөрт зарцуулсан хөрөнгийн үлдэгдэл | 38 | 6877,7 | | 6877,7 | |
| 5 | Зөрчил | Х.Пүрэвсүрэн Х.Ундраа | Дарга Ахлах мэргэжилтэн | Гүйцэтгэлийг буруу, дутуу тайлагнасан, ойн арга хэмжээнд зарцуулсан шагнал, урамшууллаас ХАОАТ аваагүй, үндсэн баримтын бүрдэл дутуу | 38 | | 43000,0 | | |
| Нийт дүн | | | | | | 13592,1 | 43000,0 | 13592,1 | |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2006 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдэлийг нөхөх зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлын 2005 оны гүйцэтгэл, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Гүйцэтгэлийн аудитын тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Сангийн сайдад хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, үр дүнг 2006 оны 10 дугаар сарын 1-ний дотор УАГ-т ирүүлэхийг Сангийн сайдад зөвлөсүгэй.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

070175
tushaal